



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

Төлөөлөгчийн газрыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын хохирол үнэлэгч “Арвижих эстимэйт” ХХК нь Орхон аймгийн Баян-Өндөр сум, Зэст баг, “Их мандал” төвийн 301 тоотод төлөөлөгчийн газар нээснийг бүртгэсүгэй.
2. Төлөөлөгчийн газар нээх болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Арвижих эстимэйт” ХХК /Ц.Хөхөөсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН